

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ. ИНЖЕНЕР - ГЕОЛОГИЙН ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН
ҮЗҮҮЛЭЛТ

MNS : 2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР
2021 ОН

ӨМНӨХ ҮГ

Стандарт, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.

Энэхүү стандартыг Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Баяртунгалаг, Г.Анхбаяр, С.Амаржаргал, доктор Б.Сайнбуян, мэргэшсэн инженер Э.Алтанбагана, З.Нямбаяр нар хамтран гүйцэтгэв.

Инженер-геологич, Монгол Улсын зөвлөх инженер О.Нарантуяа редакц хийж, Монгол Улсын зөвлөх инженер, доктор (ScD) Д.Дашжамц шүүмжийг хийв.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Энэ стандартын төслийг ТХ-36/Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Уг стандартыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ийн дагуу хянаж, боловсруулав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар хот 13348 ШХ-48

Утас: (976-51) 263860

Факс: (976-11) 458032

Цахим шуудан: standardinform@masm.gov.mn

Цахим хуудас: www.estandart.gov.mn

www.masm.gov.mn

СХЗГ 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын Төв байгууллага) -т байна.

АГУУЛГА

ОРШИЛ	1
1 Хамрах хүрээ	3
2 Норматив эшлэл	3
3 Нэр томъёо, тодорхойлолт	4
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт	4
3.2 Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт	5
4 Техникийн шаардлага	6
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага	6
4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага	8
4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага	9
4.4 UML диаграмм (норматив)	9
4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага	9
A Хавсралт – Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга	11
B Хавсралт – Кодын жагсаалт	81
C Хавсралт – UML диаграмм	135
D Хавсралт – Өгөгдлийн чанар	146

ОРШИЛ

Энэхүү стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгоно.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Стандартын техникийн шаардлагуудыг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт, олон улсын стандартын байгууллага (ISO)-ын TX 211 (ISO/TC 211-Geographic information/Geomatics) -с гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлагад тулгуурлаж, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон боловсруулав.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлэн боловсруулав.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Уг стандарт нь инженер-геологийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Инженер-геологийн ажлын зорилго нь бүс нутаг, хот тосгон, барилга байгууламжийн нутаг дэвсгэр, талбай, зурвасын геологи орчин, инженер-геологийн нөхцөлийг (хөрс чулуулаг, газрын гадаргын тогтоц, газрын доорх болон хөрсний усны нөхцөл, газар хөдлөл болон бусад геологи, инженер-геологийн үзэгдэл үйл явцын үүсэл хөгжил түүний нөлөөлөл, хөрс чулуулгийн шинж чанар, төлөв байдлыг) үнэн зөв тодорхойлох, зураг төсөл боловсруулахад шаардагдах инженер-геологийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоох, геологи орчин, инженер-геологийн нөхцлийн цаашдын хувиралт, өөрчлөлтөд үнэлэлт өгөхөд оршино. Түүнчлэн уг ангиллын мэдээлэл нь байгаль орчны төлөвлөгөөг мэдээллээр хангах, газар доорх бохирдолд өртөмтгий байдал, цаг уурын өөрчлөлтөд дохио өгөх, газрын менежмент, байгалийн нөөцийн менежмент, аюулгүй хог хаягдал зайлуулах, цацраг идэвхт хаягдал, цөмийн хаягдлыг агуулах, барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах,

барилгын материал болон ашигт малтмалаар хангах, барилга орон сууцыг барихад нөлөөлөх структур, инженерийн хүчин зүйлүүд, дэд бүтэц төлөвлөлт хийхэд суурь мэдээллээр хангаж, ингэснээр иргэд болон хот, орон нутгийн удирдлагын үйл ажиллагаа, төлөвлөлтөд ашиглах зэргээр бодлого, менежментийг сайжруулах замаар боловсруулалт хийж ашиглах боломжтой мэдээлэл агуулсан байна.

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Инженер-геологийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS ... : 2021
Geographic information. Data specification on Engineer-Geology	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны ... дугаар сарынний өдрийн дугаар тушаалаар батлав

Энэхүү стандарт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.

Стандартын шаардлага нь заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Инженер-геологийн орон зайн суурь өгөгдлийн сан нь инженер-геологийн нөхцөл, хөрс чулуулаг, газрын гадаргын тогтоц, газрын доорх болон хөрсний усны нөхцөл, газар хөдлөл болон бусад геологи, инженер-геологийн физик-геологийн үзэгдэл үйл явцын үүсэл хөгжил түүний нөлөөлөл, хөрс чулуулгийн физик-механик шинж чанар, төлөв байдлыг тодорхойлсон мэдээллийг агуулахад хамаарна.

Энэхүү стандарт нь инженер-геологийн орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд инженер-геологийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO 19107:2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;

ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;

ISO 19108-с: 2002/Cor 1:2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;

ISO 19111: 2007 Газар зүйн мэдээлэл – Оронзайн суурь солбицол;

ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;

ISO 19118: 2006, Газар зүйн мэдээлэл – Кодлолт;

ISO 19123: 2007, Газар зүйн мэдээлэл – Багц давхаргын геометр ба функцийн схем;

ISO 19125-1: 2004, Газар зүйн мэдээлэл – Энгийн биетийн хандалт - 1-р хэсэг: Нийтлэг архитектур;
ISO 19135: 2007, Газар зүйн мэдээлэл – Бүртгэлийн процедур;
ISO/TS 19138: 2006, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;
ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;
MNS 5774:2007 Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл
MNS ISO/TS 19104:2012 Газар зүйн мэдээлэл - Нэр томьёо

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

Үндсэн агуулгад хамаарах ойлголт

3.1.1

орон зайн өгөгдөл

газрын гадарга дээрх болон доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц

3.1.2

орон зайн суурь өгөгдөл

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл.

3.1.3

өгөгдлийн багц

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулгыг.

3.1.4

стерео төрөл

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрлийг.

3.1.5

өгөгдөл төрөл

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрлийг.

3.1.6

биет төрөл

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрслэгдсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрлийг.

3.1.7

кодын жагсаалт

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутадад ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

3.1.8

домэйн

Тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлнэ. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” байх ёстой гэсэн шалгуур нь домэйн болохыг.

3.2

Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт

3.2.1

Character string

Тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.2

Boolean

Тухайн мэдээлэл үнэн эсвэл худлаа гэсэн хоёр боломжит утгын аль нэгийг сонгоход хэрэглэдэг утгын төрөл юм (ихэвчлэн тийм бөгөөд үгүй гэсэн төрөл ашигладаг). [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.3

Date time

Цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.4

GM_Point

Цэг бол зөвхөн нэг цэгээс бүрдэх геометр объектын өгөгдлийн үндсэн төрөл юм. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.5

GM_Polygon

Суурийн гадаргуу болон түүнийг хүрээлэх хил заагаар тодорхойлогдох гадаргуугийн цогц юм. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.6

GM_Object

Геометрийн объектын ангилал зүйн язгуур анги бөгөөд газар зүйн хувьд хамааралтай бүх геометрийн объектуудыг төлөөлдөг. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.7

Integer

Тоон мэдээллийн хуваагдаагүй, задгай нэгж ашиглаагүй бүхэл утга байна. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.8


Measure

Хэмжилтийн үр дүнд гаргасан хэмжигдэхүүний тоон утга. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

4 Техникийн шаардлага

4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох “**өгөгдлийн багц**”, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй “**атрибут**”, атрибутад орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан “**кодын жагсаалт**” гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй (1-р зурагт тоймлон үзүүлэв) байхыг шаардана.



1-р зураг – Инженер-геологийн өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 А хавсралтаар орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утгад ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

4.1.4 Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «кодын жагсаалт» гэсэн стерео төрөлтэй байх норматив шаардлагыг хангана.

4.1.5 Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

4.1.6 Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

4.1.7 Инженер-геологийн орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хүснэгтийн дагуу **инженер-геологи, гидрогеологи, геоморфологи, газар чичирхийлэл, газар хөдлөл, геологи** гэсэн 5 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

4.1.8 Инженер-геологийн орон зайн өгөгдлийн санд 36 биет төрөл, 10 өгөгдөл төрөл агуулна.

4.2 Атрибутаг тавигдах (норматив) шаардлага

4.2.1 Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн норматив шаардлагыг хангана.

4.2.2 Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

4.2.3 Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /External id/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /Local id/, “нэрийн талбар” /Name space/, “танигчийн хувилбар” /Version id/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005].

4.2.3.1 “Дотоод танигч /Local id/” нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.

4.2.3.2 “Нэрийн талбар /Name space/” нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4.2.3.3 “Танигчийн хувилбар /Version id/” нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.

4.2.4 Инженер-геологийн орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1 –д заасан “Газар зүйн нэр” /Geographical name/ дэд өгөгдлийн сантай холбогдоно.

4.2.4.1 “Газар зүйн нэр” /Geographical name/ нь тухайн инженер-геологийн “Газар зүйн нэр” /Geographical name/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Газар зүйн нэр» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газар зүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлт MNS ...:2021” стандартаас авч ашиглана.

4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага

4.3.1 А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

4.3.2 Инженер-геологийн орон зайн өгөгдлийн санд 73 кодын жагсаалт агуулна.

4.3.3 А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утгад заасан кодын жагсаалтын дагуу ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

4.4 UML диаграмм (норматив)

4.4.1 Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language)-ын дагуу өгөгдлийг загварчилна.

4.4.2 Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

4.4.3 С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна инженер-геологийн орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага

4.5.1 Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь инженер-геологийн суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.13-р хүснэгтэд үзүүлснээр дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

4.5.2 Инженер-геологийн суурь орон зайн өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана.

4.5.2.1 Утга агуулгын нийцтэй байдал: өгөгдлийн бүтэц, атрибут ба харилцан хамаарлуудын логик дүрмүүдийг баримтлах түвшин.

ТӨГСӨВ

ТӨСӨЛ

А Хавсралт
(норматив)

Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

А. 1-р хүснэгт – Инженер-геологийн орон зайн суурь өгөгдлийн багц ба стерео төрлүүд

А.1.1 Өгөгдлийн багц: Инженер-геологийн суурь өгөгдөл (Engineer-geology)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Гарал үүслийн бүрдлүүд / <i>Geological origin</i> /	«биет төрөл» «feature type»	Полигон	Формацууд ба геологийн гарал үүслийн бүрдлүүд.
2	Ул хөрсний бүрэлдэхүүний төрөл / <i>Sub soil composition value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Бүрдлүүдийн өнгөн хэсгийн ул хөрсний бүрэлдэхүүн.
3	Цэвдэг гидрогеологийн нөхцөл / <i>Permafrost hydrogeological condition</i> /	«биет төрөл» «feature type»	Полигон, шулуун, цэг	Цэвдэг гидрогеологийн нөхцөл: уст цэг, болон газрын доорх усны найрлага ба хатуулаг, уст горизонт, болон геокриологийн бүсүүд.
4	Физик-геологийн үзэгдэл үйл явц / <i>Geological process</i> /	«биет төрөл» «feature type»	Полигон, шулуун, цэг	Физик-геологийн үзэгдэл үйл явц (түүний тархалтын дүүргүүд).
5	Инженер геологийн биет / <i>Engineer geological complex</i> /	«биет төрөл» «feature type»	Полигон	Хот суурин, барилга байгууламж шинээр төлөвлөх нутаг дэвсгэр, талбайн геологи, геоморфологийн тогтоц, физик геологийн үзэгдэл, үйл явцын эрчим, хөгжил, гидрогеологи, геокриологийн нөхцөл зэрэг байгалийн хүчин зүйлүүдийн орон зайн тархалт, байрлал, ул хөрсний инженер-геологийн элементүүдийн шинж чанар зэргийг инженер-геологийн шинжлэх ухааны үүднээс нэгтгэн дүгнэсэн иж бүрдэл.
6	Ул хөрсний хэмжээ, ангилал / <i>Soil group value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хөрсний бүлгийн ангилал.
7	Эрин / <i>Era value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Эрин.

8	Систем /System for engineer-geology value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Давхарга зүйн системүүд.
9	Сери / Series for engineer-geology value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Сери.
10	Гарал үүсэл /Origin for engineer-geology value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гарал үүсэл.
11	Хөрсний мэдээлэл /Soil information/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Хөрсний мэдээлэл.
12	Ул хөрсний зузааны бүлэг, ангилал /Soil complex type value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Ул хөрсний зузаан, бүлгээр.
13	Ул хөрсний зузааны хэмжээ, ангилал /Soil complex size value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Ул хөрсний зузааны хэмжээ.
14	Ул хөрсний нэр, ангилал /Soil name value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Ул хөрсний нэрийн ангилал.
15	Байгалийн чийг, хэмжээ /Moisture value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Байгалийн чийг, /нэгж/.
16	Консистенци /хам байдал/ ангилал /Context value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Консистенцийн ангилал.
17	Хүйтний овойлтын зэрэг /хэмжээ/, ангилал /Rf-value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Овойлтын зэргийн ангилал.
18	Газар шорооны ажлын зэрэг, ангилал /Soil excavation value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар шорооны ажлын зэргийн ангилал.
19	Онцгой шинж чанартай ул хөрсний хэмжээ, ангилал /Special soil value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Онцгой шинж чанартай ул хөрсний хэмжээ, ангилал.
20	Цэвдгийн мэдээлэл /Permafrost information/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Цэвдгийн мэдээлэл.
21	Олон жилийн цэвдэг ул хөрсний тогтоц, ангилал /Permafrost value/	«кодынЖагсаалт»	Ангилал	Олон жилийн цэвдэгт ул хөрс.
22	Хөөлттэй болон суулттай ул хөрсний мэдээлэл /Swelling value/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Хөөлттэй хөрсний мэдээлэл.

23	Хөөлттэй ул хөрсний хэмжээ, ангилал <i>/Swelling value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хөөлттэй ул хөрсний хэмжээ.
24	Суулттай ул хөрс, ангилал <i>/Loess value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Суулттай ул хөрсний хэмжээ, ангилал.
25	Хөөлттэй ул хөрсний бүсчлэл <i>/Swelling soil zoning/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Хөөлттэй хөрсний мужлалт.
26	Хөөлттэй ул хөрсний бүсчлэлийн төрөл, ангилал <i>/Swelling region value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Региональ-геологийн таксономын нэгж.
27	Хөөлттэй ул хөрсний мужуудын жагсаалт <i>/List of swelling region value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Дэд регион, регион болон мужуудын жагсаалт.
28	Хөөлттэй хөрсний тархалтын ангилал <i>/Swelling soil distribution value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хөөлттэй хөрсний тархалтын онцлог.
29	Хөрсний үе <i>/Soil Layer/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Хөрсний үе.
30	Хөрсний тархалтын хил зааг <i>/Soil boundary/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Хөрсний тархалтын хил зааг.
31	Хөрс, чулуулгийн хил заагийн төрөл, ангилал <i>/Soil boundary type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хөрс, чулуулгийн хил заагийн төрөл.
32	Инженер-геологийн дагалдах нөхцөл: Шугаман объектууд <i>/Ancillary condition-line object/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Инженер-геологийн дагалдах нөхцөл шугаман мэдээлэл.
33	Инженер-геологийн дагалдах нөхцөл: Цэгэн объектууд <i>/Ancillary condition-point object/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Инженер-геологийн дагалдах нөхцөлийн цэгэн мэдээлэл.
34	Инженер-геологийн зураглалын ажлын төрөл, хэмжээ, бүсчлэлийн үндсэн ангилал <i>/Ancillary condition major type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Инженер-геологийн дагалдах нөхцөлийн үндсэн ангилал.
35	Инженер-геологийн зураглалын ажлын төрөл, хэмжээ, бүсчлэлийн дэд ангилал <i>/Ancillary condition sub type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Инженер-геологийн дагалдах нөхцөлийн дэд ангилал.

36	Инженер-геологийн зүсэлтийн шугам <i>/Engineer geological profile/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Инженер-геологийн зүсэлтийн шугам.
37	Инженер-геологийн мужлал <i>/Engineer geological region/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Инженер-геологийн мужлал.
38	Инженер-геологийн мужлалын хил зааг <i>/Engineer geological region boundary/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Инженер-геологийн мужлалын хил заагийн төрөл.
39	Инженер-геологийн бүсийн ангилал <i>/EG region boundary value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Инженер-геологийн мужлалын хил заагийн ангилал.
40	Инженер-геологийн цооног <i>/Engineer geological borehole/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Инженер-геологийн цооногийн бичиглэл.
41	Цооногийн хөрсний мэдээлэл <i>/Borehole soil information/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Цооногийн хөрсний мэдээлэл.
42	Цооногийн каталог <i>/Borehole catalogue/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Цооногийн каталог.
43	Цооногийн хэмжээ, төрөл, ангилал <i>/Borehole type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Цооногийн төрөл.
44	Геокриологийн бүслүүр <i>/Geocryology/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Геокриологийн бүслүүр.
45	Геокриологийн бүслүүрийн төрөл, ангилал <i>/Geocryology type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Геокриологийн бүслүүрийн төрөл.
46	Хөлдөлт гэсэлтийн хил <i>/Freezing/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Хөлдөлт гэсэлтийн хил.
47	Цэвдгийн хэлбэрүүд <i>/Permafrost type/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Цэвдэгт хотгор, гүдгэрийн хэлбэрүүд.
48	Цэвдгийн хэлбэрүүдийн төрөл, ангилал <i>/Permafrost type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Цэвдэгт хотгор, гүдгэрийн хэлбэрүүдийн төрөл.

А.1.2 Өгөгдлийн багц: Гидрогеологийн суурь өгөгдөл (Hydrogeology)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Гидрогеологийн мужлалт <i>/Hydrogeological region/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Гидрогеологийн мужлал.
2	Гидрогеологийн мужлалын төрөл <i>/Hydrogeological region type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гидрогеологийн мужлалын төрөл.
3	Гидрогеологийн дэд мужлал <i>/Hydrogeological region sub type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гидрогеологийн дэд мужууд.
4	Гидрогеологийн нэгж <i>/Hydrogeological unit/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Формацууд ба геологийн гарал үүслийн бүрдлүүд.
5	Гидрогеологийн бүрдэл бүсүүдийн гадаргуун тархалтын ангилал <i>/Hydrogeological distribution value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гидрогеологийн бүрдэл бүсүүдийн гадаргуун тархалт.
6	Гидрогеологийн бүрдлүүдийн ангилал <i>/Hydrogeological components value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газрын доорх ус агуулсан үе давхарга бүрдлүүд.
7	Чулуулгийн нэр, ангилал <i>/Rock name value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Зонхилох чулуулгийн нэр.
8	Гарал үүслийн бүрдлүүд, ангилал <i>/Components origin value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гарал үүслийн төрөл.
9	Гидрогеологийн шугаман объектын <i>/Hydrogeological line object/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Гидрогеологийн шугаман объектын.
10	Гидрогеологийн шугаман объектын хэмжээ, ангилал <i>/Hydrogeological line object value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гидрогеологийн шугаман объектын төрөл.
11	Усны эрдэсжилтийн утга <i>/Water mineralization zone/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Усны эрдэсжилтийн утга.
12	Олон жилийн цэвдэгийн бүсчлэл ба хэмжээ <i>/Permafrost zone/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Уст үе үл нэвтрүүлэх үеийн цэвдэгшлийн хүрээ.
13	Цэвдэгшлийн хүрээний төрөл, ангилал <i>/Permafrost zone type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Уст үе үл нэвтрүүлэх үеийн цэвдэгшлийн хүрээний ангилал.
14	Гидрогеологийн объект <i>/Hydrogeological object/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон, Цэг	Гидрогеологийн системтэй харилцан уялдаатай байдаг хүний гараар бүтсэн байгууламж эсвэл байгалийн биет бүхий абстракт

				анги /Гидрогеологийн объект нь байгалийн (жич. Булаг шанд) эсвэл хүний гараар бүтсэн (жич. худаг) байж болно.
15	Гидрогеологийн хиймэл объект <i>/Hydrogeological object man made/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Хиймэл гидрогеологийн объект. /жишээ нь: худаг, газар доорх уснаас ус татах, газар доорх усны хяналтын төв эсвэл хяналтын цооног/.
16	Гидрогеологийн хиймэл объектын ангилал <i>/Hydrogeological object man made value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гидрогеологийн хиймэл объектын ангилал.
17	Гидрогеологийн байгалийн объект <i>/Hydrogeological object natural/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Байгалийн процессуудын үр дүнд үүссэн гидрогеологийн объект.
18	Гидрогеологийн байгалийн объектын ангилал <i>/Hydrogeological object natural value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гидрогеологийн байгалийн объектын ангилал.
19	Хүйтний гаралтай үзэгдэл <i>/Permafrost natural object/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Хүйтний гаралтай үзэгдэл.
20	Хүйтний гаралтай үзэгдлийн ангилал <i>/Permafrost natural object value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хүйтний гаралтай үзэгдлийн ангилал.
21	Уст давхаргын ангилал <i>/Aquifer type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Уст давхаргын ангилал.
22	Гидрогеохимийн төрөл, ангилал <i>/Hydro geochemical type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гидрогеохимийн төрөл.
23	Анионы бүрэлдэхүүний ангилал <i>/Anion composition value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Тулгуур уст цэгүүдийн усны анионы бүрэлдэхүүний ангилал.
24	Газрын доорх усны орд <i>/Groundwater resource/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон, Шулуун	Газар доорх усны прогноз нөөц, ашиглахад бэлэн орд, нарийвчлан судалгаа хийх шаардлагатай орд талбай.
25	Устай цэгүүд <i>/Groundwater points/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Устай цэгүүд (Хүний үйл ажиллагаагаар үүссэн, байгалийн горимоор үүссэн булаг).
26	Устай цэгүүдийн төрөл, ангилал <i>/Groundwater point value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Устай цэгүүдийн төрөл.
27	Газрын доорх усны ордын цооног <i>/Groundwater resource drillhole/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Газрын доорх усны ордуудын цооногийн мэдээлэл.
28	Газрын доорх усны ордын цэгэн мэдээлэл <i>/Groundwater resource point/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Газрын доорх усны ордын цэгэн мэдээлэл.

А.1.3 Өгөгдлийн багц: Геоморфологи суурь өгөгдөл (Geomorphology)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Геоморфологийн мужлал /Geomorphological region/	«биет төрөл» «feature type»	Полигон, шулуун	Гарал үүслийнх нь хувьд геоморфологийн мужлалд үүсгэсэн орон зай агуулсан үр дүн.
2	Геоморфологийн мужлалын нэр, ангилал /Geomorphological region value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Геоморфологийн мужлалын нэр.
3	Геоморфологийн хэв шинж /Geomorphological type/	«биет төрөл» «feature type»	Полигон	Геоморфологийн үндсэн ба дэд хэв шинж, тайлбар.
4	Хотгор гүдгэрийн гарал үүслийн бүлэг, ангилал /Depression origin value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хотгор гүдгэрийн гарал үүслийн бүлэг.
5	Геоморфологийн хэв шинж, ангилал /Geomorphological type value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хотгор гүдгэрийн хэв шинж.
6	Геоморфологийн дэд хэв шинж, ангилал /Geomorphological sub type value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хотгор гүдгэрийн дэд хэв шинж.
7	Геоморфологийн гадаргын цэгэн хэлбэр /Geomorphological surface shape point/	«биет төрөл» «feature type»	Цэг	Цэгэн дүрсээр илэрхийлэгдэх гадаргын хэлбэрүүд.
8	Гадаргын цэгэн хэлбэрийн төрөл, ангилал /Surface shape point value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гадаргын цэгэн хэлбэрийн төрөл..
9	Геоморфологийн гадаргын шугаман хэлбэр /Geomorphological surface shape line/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Шугаман дүрсээр илэрхийлэгдэх гадаргын хэлбэрүүд.
10	Гадаргын шугаман хэлбэрийн төрөл, ангилал /Surface shape line value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гадаргын шугаман хэлбэрийн төрөл.

А.1.4 Өгөгдлийн багц: Газар чичирхийлэл, газар хөдлөлийн суурь өгөгдөл (Seismic and earthquake)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
-----	---------------	--------------	---------------	--------------

1	Газар хөдлөлтийн ерөнхий мужлал <i>/General seismic region/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Газар хөдлөлтийн ерөнхий мужлал.
2	Газар хөдлөлтийн бичил мужлал <i>/Micro seismic region/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Газар хөдлөлтийн бичил мужлал.
3	Газар чичирхийллийн мужийн шатлал <i>/MSK-64 value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар чичирхийллийн муж (MSK -64 шатлалын баллаар) - ын шатлал.
4	Газар хөдлөлтийн төвүүд <i>/Earthquake centers/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Газар хөдлөлтийн төвүүд.
5	Газар хөдлөлтийн төвүүдийн ангилал <i>/Earthquake center value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар хөдлөлтийн төвүүдийн ангилал.
6	Газар чичирхийллийн мужийн хил <i>/Seismic region boundary/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Газар чичирхийллийн мужийн хил.
7	Газар чичирхийллийн мужийн хилийн төрөл <i>/Seismic region boundary value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар чичирхийллийн мужийн хилийн төрөл.
8	Газар хөдлөлтийн голомт үүсэж болох бүсийн ангилал <i>/Earthquake center zone value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар хөдлөлтийн голомт үүсэж болох бүсийн ангилал.

А.1.5 Өгөгдлийн багц: Геологийн суурь өгөгдөл (Geology)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Геологийн биет <i>/Geology complex/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Тусгай шинж чанартай чулуулгийн масс. /Албан ёсны нэгжийг (жишээ нь албан ёсоор хүлээн авсан ба албан ёсны нэр томъёо дээр нэрлэсэн) ба албан бус нэгжүүдийг (ж.нь нэрлэсэн боловч нэр томъёо дээр оруулаагүй), нэрлээгүй хэсгүүдийг (ж.нь энэ салбарт танигдах боломжтой ба тайлбарлах боломжтой, гэхдээ энэ нь өөр хэлбэрээр албан ёсоор батлагдаагүй) багтана.
2	Геологийн нэгжийн хил <i>/Boundary of geological unit/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Геологийн нэгжийн хил.
3	Серийн легендийн ангилал <i>/Series legend value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Аль серид хамаарагдаж байгааг мэдээллэнэ.

4	Тектоникийн бүсийн ангилал <i>/Tectonic zone value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Тектоникийн бүс.
5	Геологийн биетийн хэлбэр, ангилал <i>/Shape of geological body value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Геологийн биетийн хэлбэр..
6	Эонотем <i>/Eonothem value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Эонотем.
7	Эратем <i>/Erathem value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Эратем.
8	Систем <i>/Geology system value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Систем.
9	Сери <i>/Geology series value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Сери.
10	Стейж <i>/Stage value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Стейж.
11	Фаз <i>/Phase value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Фаз.
12	Чулуулгийн нэр, ангилал <i>/Rocks type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Чулуулаг.
13	Структур <i>/Structure value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Структур.
14	Текстур <i>/Texture value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Текстур.
15	Гарал үүслийн төрөл, ангилал <i>/Type of geological origin value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Гарал үүслийн төрөл.
16	Улалдаг болон хучдаг хурдас хил заагийн төрөл, ангилал <i>/Boundary type with under overlain value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Улалдаг болон хучдаг хурдас хил заагийн төрөл. Үл нийцлэг хил, интрузив бүрдэл зүссэн. Жишээ нь: Үл нийцлэг, тектоник хил зааг гэх мэт.
17	Улалдаг болон хучдаг хурдас үл нийцлэгийн төрөл, ангилал <i>/Unconformity type with under overlain value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Улалдаг болон учдаг хурдас үл нийцлэгийн төрөл. Давхаргазүйн тасалдалтай үл нийцлэг. Жишээ нь: Давхаргазүйн үл нийцлэг, өнцгийн үл нийцлэг гэх мэт.

18	Хагарал / <i>Fault</i> /	«биет төрөл» «feature type»	Шугаман	Тектоник хагарлын төрлийн тайлбарласан нэр томьёо. Жишээ нь: хөнтрүү хагарал, энгийн хагарал. Тасралтат эвдрэлийн (хагарлын) болон харьцуулалт (корреляци) хийх боломжгүй болсон бүсүүдийн (геофизикийн мэдээгээр үндэслэсэн баримжаалсан хагарлууд) тухай бүх мэдээллүүд тухайн хагарлын хэмжээ, ач холбогдол, баталгаажилтын зэрэг, харьцангуй хучиж буй хурдас болон морфогенетикийн онцлогуудаас үл хамааран бүгд тэмдэглэгдэнэ.
19	Хагарлын төрөл, ангилал / <i>Fault type value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хагарлын төрөл.
20	Дөрөвдөгчийн хурдас / <i>Quantenary</i> /	«биет төрөл» «feature type»	Полигон	Дөрөвдөгчийн хурдсын хэв шинж, хурдсын нас, гарал үүслийн төрөл, литологийн бүрэлдэхүүн, суурь чулуулгийн төрөл зэрэг мэдээллийг агуулсан байна.
21	Дөрөвдөгчийн хурдсын нас, ангилал / <i>Quantenary age value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Дөрөвдөгчийн хурдасны нас.
22	Дөрөвдөгчийн гарал үүслийн төрөл, ангилал / <i>Quantenary origin value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Дөрөвдөгчийн гарал үүслийн төрөл.
23	Литологийн бүрэлдэхүүн, ангилал / <i>Quantenary lithology value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Дөрөвдөгчийн литологийн бүрэлдэхүүн.
24	Үндсэн чулуулгийн төрөл, ангилал / <i>Quantenary rock type value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Үндсэн чулуулгийн төрлүүд.
25	Үндсэн чулуулгийн дэд төрөл, ангилал / <i>Quantenary rock sub type value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Үндсэн чулуулгийн дэд төрлүүд.

А. 2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн давхаргын атрибутын агуулга

А.2.1 Өгөгдлийн багц – Инженер-геологийн суурь өгөгдөл (Engineer-geology)

А.2.1.1 Биет төрлийн нэр: Гарал үүслийн бүрдлүүд (Geological origin)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	GM_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Орон зайн объектын геометр дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Нарийвчлалын түвшин /Level of detail/	Дүрслэх чадвар /MD_Resolution/	Тэмдэгтийн мөр /Character string/	10	Тухайн объектын орон зайн нарийвчлалыг илэрхийлнэ.
8	Формац /Formations/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	300	Эх газрын молласлаг тунамал формац.

9	Формац ба дээд, доод зузаалгийн индекс /Formations index/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	20	Формац ба дээд, доод зузаалгийн индекс
10	Формац ба геологийн гарал үүслийн тодорхойлолт /Formations geological definition/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Формац ба геологийн гарал үүслийн тодорхойлолт
11	Ул хөрсний бүрэлдэхүүн /Sub soil composition/	Ул хөрсний бүрэлдэхүүний төрөл /Sub soil composition value/	-	-	Бүрдлүүдийн өнгөн хэсгийн ул хөрсний бүрэлдэхүүний тодорхойлолт. Sub soil composition value – кодын жагсаалтын утгаас авч ашиглана.
12	Бүрдэл /Composition/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	300	Геологийн нас.
13	Чулуулаг /Rocks/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	300	Гарал үүсэл бүс.
14	Хурдас /Alluvium/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	300	Геологийн нас.
15	Литологи /Lithology/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	300	Найрлага.
16	Индекс /Index/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	20	Индекс томъёо.

А.2.1.2 Биет төрлийн нэр: Цэвдэг гидрогеологийн нөхцөл (Permafrost hydrogeological condition)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Объект /GM_Object/	-	-	Орон зайн объектын геометр дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Нарийвчлалын түвшин /Level of detail/	Дүрслэх чадвар /MD_Resolution/	Тэмдэгтийн мөр /Character string/	10	Тухайн объектын орон зайн нарийвчлалыг илэрхийлнэ.
8	pH	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Double/	7	pH- устөрөгчийн ионы концентрац.
9	HCO	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Double/	7	HCO ₃ түр зуурын хатуулаг.
10	CO₂	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Double/	7	CO ₂ –усны идэмхий чанарууд.
11	SO₄	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Double/	7	SO –хүхэрлэг чанар.
12	Грунтын усны төвшин /Water level/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Double/	7	Тухайн уст цэг дээр хэмжигдсэн грунтын усны төвшин (метрээр).
13	Гидрогеологи /Permafrost hydrogeology/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Цэвдэг гидрогеологийн нөхцөл, уст горизонт, болон геокриологийн бүсүүд.
14	Уст горизонтын гүн /Horizon depth/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Double/	7	Уст горизонтын эхний (тогтонги) төвийн хүртэл гүн (метрээр).
15	Цэвдэг чулуулаг /Permafrost rocks/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Мөнхцэвдэг чулуулгийн тархалт.

16	Мөнхцэвдэгийн зузаан /Permafrost thickness/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Double/	7	Мөнхцэвдэгийн зузаан(м)-эр.
17	Мөнхцэвдэгийн зузаан /Permafrost temperature/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Double/	5	Мөнхцэвдэгийн дундаж хэм (°C).
18	Цэвдэгт үзэгдлийн нэр, төрөл /Permafrost phenomenon/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Цэвдэгт үзэгдлийн нэр, төрөл.

А.2.1.3 Биет төрлийн нэр: Физик-геологийн үзэгдэл, үйл явц (Geological process)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Объект /GM_Object/	-	-	Орон зайн объектын геометр дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Нарийвчлалын түвшин /Level of detail/	Дүрслэх чадвар /MD_Resolution/	Тэмдэгтийн мөр /Character string/	10	Тухайн объектын орон зайн нарийвчлалыг илэрхийлнэ.

8	Газар хөдлөлт /Earthquake/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Double/	5	Газар хөдлөлт (баллаар).
9	Геологийн үзэгдэл, үйл явц /Geological process/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Орчин үеийн геологийн үйл явц түүний тархалтын дүүргүүд.
10	Нэр, төрөл /Name type/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Нэр, төрөл.
11	Инженер-геологийн муж /Engineer geology region/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	20	Инженер-геологийн мужуудын жагсаалт.
12	Тектоникийн хил зааг /Tectonic information/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Нэг төрлийн настай боловч фацийн ялгаралтай хурдаснуудын хил зааг болон тектоникийн хил зааг.
13	Тогтоогдсон тулгуур үеүдийн тодорхойлолт /Description/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Зургийн тайлал ба мөрдөх маршрутаар тогтоогдсон тулгуур үеүдийн тодорхойлолт.
14	Тогтоогдсон тулгуур үеүдийн төрөл /Type/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Зургийн тайлал ба мөрдөх маршрутаар тогтоогдсон тулгуур үеүдийн төрөл.
15	Палеонтологийн олдворын төрөл /Paleontological type/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Палеонтологийн олдворын төрөл.
